



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨРИЙН САНГИЙН ТОГТОЛЦОО БОДЛОГО, ЧИГ ҮҮРГИЙГ ШИНЭЧИЛЖ,
ХАРИУЦЛАГЫН ТОГТОЛЦООГ ЭРХ ЗҮЙН АКТУУДАД НАРИЙВЧЛАН ТУСГАХ
ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

ТӨРИЙН САНГИЙН ТОГТОЛЦОО, ХУУЛЬ ТОГТООМЖИЙН НИЙЦЭЛ

АУДИТЫН КОД: ЗАА-2026/14-12/ШТА-НА



Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа
Утас: 7046-3612, Цахим хаяг: bat-undraad@audit.gov.mn

Аудитын менежер Х.Болдбаатар
Утас: 7046-3783, Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn

Аудитор Д.Пүүжмаа
Утас: 99080797, Цахим хаяг: puujmaad@audit.gov.mn

Аудитор Г.Баасанжаргал
Утас: 99032514, Цахим хаяг: baasanjargalg@audit.gov.mn

Аудитор Г.Нармандах
Утас: 99031794, Цахим хаяг: narmandakhg@audit.gov.mn

Улиастай хот 2026

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
www.audit.mn хаягаас үзнэ үү.



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ**

2026 оны 05 сарын 29 өдөр

Дугаар 4/16

Улиастай

“Төрийн сангийн тогтолцоо, хууль
тогтоомжийн нийцэл” сэдэвт
аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18.9, 2025 оны А/175 дугаар тушаалын гуравдугаар хавсралтаар баталсан “Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх”-ийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн нийцэл” сэдэвт аудитын тайланг нэгдүгээр хавсралтаар баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, болон аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс, сумдын төрийн сангийн албан хаагчид, холбогдох бусад газруудад хүргүүлэхийг шинжээч (У.Хорлоо)-д, audit.mn цахим хуудсаар нийтэд мэдээлэхийг аудитор (Г.Нармандах)-д үүрэг болгосугай.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг тогтоосон хугацаанд ирүүлэхийг холбогдох албан тушаалтнуудад зөвлөсүгэй.

4. Нийцлийн аудитын тайланд тусгагдсан зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж, аудитын ажлын болон нотлох баримтыг 2026 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн дотор архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг (аудитор Д.Пүүжмаа)-т даалгасугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Х.Болдбаатар)-т үүрэг болгосугай.



Д.БАТ-УНДРАА

АГУУЛГА

Тайлан бэлтгэсэн:

Завхан аймаг дахь
Төрийн аудитын газар

Тэргүүлэх аудитор
Д.Бат-Ундраа
Аудитын менежер
Х.Болдбаатар
Аудитор
Д.Пүүжмаа
Г.Баасанжаргал
Г.Нармандах

Аудитын тайлан,
дүгнэлттэй
холбоотой асуудлаар
нэмж тодруулах, асууж
лавлах зүйл гарвал
9908079 дугаарын
утсаар харилцана уу.

ХАЯГ: Улиастай сум
Нутгийн удирдлагын
ордон 3 давхар

Цахим хаяг:
audit.mn/

2026 оны 05 дугаар
сар

Товчилсон үгийн жагсаалт

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Ерөнхий мэдээлэл

БҮЛЭГ 1. ХУУЛЬ, ЖУРАМД ЗААСАН ТӨРИЙН САНГИЙН ТОГТОЛЦОО БОДЛОГО, ЧИГ ҮҮРГИЙГ ШИНЭЧЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

А.1 ТЕЗ-ийн гаргасан төрийн сангийн үйл ажиллагааны эрх зүйн акт нь холбогдох хууль тогтоомжтой нийцэж байна.

А.2 Төрийн сангийн чиг үүргийг хэрэгжүүлж байгаа албан тушаалтнууд засаг даргын тамгын газарт харьяалагдан үйл ажиллагаагаа явуулж байгаа нь орон нутаг дахь төрийн сангийн хараат бус байдал хангагдахгүй байна

БҮЛЭГ 2. ТӨРИЙН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ӨДӨР ТУТМЫН ХЯНАЛТ СУЛ БАЙГААГААС ТӨРИЙН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА

Б.1 Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийг батлагдсан төсөв, төсвийн хуваариар, журамд заасан хугацаандаа олгохгүй байгаа нь Сангийн яамнаас олгож байгаа санхүүжилт тухайн сарын 5-8-ны хооронд олгогдож байгаагаас шалтгаалжээ..

Б.2 Төрийн сангийн, төлбөр тооцооны үйл ажиллагаа хууль, журмын дагуу хэрэгжиж байгаа боловч зарим гүйлгээнд анхан шатны баримтын бүрдэл дутуу, эдийн засгийн ангилал зөрчсөн гүйлгээ болон дансны үлдэгдлийг хянаж баталгаажуулаагүй, зөрчлүүд илэрч байна.

Б.3 Төрийн сангийн үйл ажиллагаанд, өдөр тутмын хяналтын тогтолцоог үр нөлөөтэй хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Дүгнэлт

Зөвлөмж

Зөрчлийн жагсаалт

Хавсралтууд

Холбогдох байгууллагын санал

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ҮАГ	Үндэсний Аудитын Газар
ТЕЗ	Төсвийн Ерөнхийлөн Захирагч
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
ОНХС	Орон Нутгийн Хөгжлийн Сан
ЗГСУМС	Засгийн Газрын Санхүүгийн Удирдлагын Мэдээллийн Систем
ХХОАТ	Хувь Хүний Орлогын Албан Татвар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТАЦНС	Төрийн Албаны Цалингийн Нэгдсэн систем

ХҮСНЭГТ, ГРАФИКИЙН ТОВЬЁГ

№	Тайлбар	Хуудасны дугаар
1	Хүснэгт №1 Давхардсан чиг үүргүүд	8
2	График № 1. Санал асуулга 1	8
3	График № 2. Санал асуулга 2	9
4	Хүснэгт №2 Нэмэлт санхүүжилтийн төсвийн мэдээ	13
5	График № 3. Санал асуулга	15
6	Хүснэгт №3 Зөрчлийн дэлгэрэнгүйг хүснэгт	15-16
7	Хүснэгт №4 Төсвийн жилийн хугацаанаас хойш илгээгдсэн	17
8	Хүснэгт №5 Сарын бүрийн эцсийн ажлын өдрийн хугацаанаас хойш илгээгдсэн	18
9	График № 4. Тодорхойгүй гүйлгээ, анхан шатны баримт бүрдүүлэлт	19
10	Хүснэгт №5 Тодорхойгүй гүйлгээ	19
11	Хүснэгт 6 Төрийн сангаас 2023-2025 онд хэрэгжүүлсэн төлөвлөгөөт хяналтын талаарх мэдээлэл	23

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт арга зүй
Аудитын зорилт	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2025 оны “Аудитын сэдэв батлах тухай” 25 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагын 2026 онд гүйцэтгэх аудитын жилийн төлөвлөгөө”-г үндэслэн хийж гүйцэтгэсэн. Аймгийн Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн хэрэгжилтэд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан Завхан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулан, Үндэсний аудитын газарт хүргүүлж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн. Уг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: • <i>Төрийн сангийн тогтолцоо оновчтой бүрдсэн эсэх;</i> • <i>Төрийн сангийн үйл ажиллагааг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлсэн эсэх;</i>
Аудитын хамарсан хүрээ	Аудитаар Монгол Улсад төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааг тодорхойлсон бодлого, хууль тогтоомжийн нийцэл, аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч болон Төрийн сангийн удирдлагын цахим системийг /цаашид ТСУЦС гэх/ ашигладаг бусад төрийн байгууллагуудын 2023-2025 оны төрийн сангийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайланг хамруулан, бүтцийн зохион байгуулалт, чиг үүрэг оновчтой эсэх, хэрэгжүүлж буй арга хэмжээний үр дүн, үр нөлөөнд үнэлгээ хийж гүйцэтгэсэн.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-6:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/71 дүгээр тушаалаар баталсан “Нийцлийн аудитын заавар, аргачлал”-ыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулсан.

**Аудитын багийн
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа, аудитын менежер Х.Болдбаатар нар хянан удирдаж, аудитор Д.Пүүжмаа, аудитор Г.Баасанжаргал, аудитор Г.Нармандах нар 2026 оны 03 дугаар сарын 31-ний өдрөөс 2026 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.

**Аудитын ерөнхий
мэдээлэл**

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.40-д “төрийн сангийн үйл ажиллагаа гэж төсөв, мөнгөн хөрөнгө, өр төлбөрийн удирдлагыг хэрэгжүүлэх, төлбөр тооцоог гүйцэтгэх, төсвийн гүйцэтгэлийг тайлагнахыг” гэж тодорхойлж, мөн хуулийн 35, 36, 37, 38 дугаар зүйлд төрийн сангийн нэгдсэн данс, тогтолцоо, нийтлэг чиг үүрэг, төв төрийн сан, аймаг, нийслэл, улсын зэрэглэлтэй хотын төрийн сан, сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төрийн сан, төрийн захиргааны төв байгууллагын төрийн сангийн нэгж, төсвийн нягтлан бодогчдын чиг үүргүүдийг хуульчилсан байна.

Завхан аймгийн хэмжээнд Санхүү, төрийн сангийн хэлтэс, 24 сумын Санхүүгийн алба, нийт 25 төрийн санд 54 албан хаагч үйл ажиллагаагаа явуулж байна. Завхан аймгийг системийн хэрэглэгчээр нь авч үзвэл Эрхийн бүртгэлийн болон Төрийн сангийн удирдлагын цахим системийн хувьд 307 төсвийн байгууллага, 1285 данс, 660 системийн хэрэглэгч, Төрийн албаны цалингийн нэгдсэн системийн хувьд 307 төсвийн байгууллага, 5311 цалин тооцоолж буй төрийн албан хаагч байна.

Завхан аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтсээс ирүүлсэн 2025 оны урьдчилсан төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр 2025 оны орон нутгийн татварын орлогын гүйцэтгэл 37.1 тэрбум, ОНХС-ийн орлогын шилжүүлэг 12.4 тэрбум, Сангийн яамны санхүүгийн дэмжлэг 35.9 тэрбум, нийт 85.4 тэрбум төгрөгийн орлогын, 83.7 тэрбум төгрөгийн зарлагын гүйцэтгэлтэй ажилласан байна.

БҮЛЭГ 1.ХУУЛЬ, ЖУРАМД ЗААСАН ТӨРИЙН САНГИЙН ТОГТОЛЦОО БОДЛОГО, ЧИГ ҮҮРГИЙГ ШИНЭЧЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

1.1.ТЕЗ-ийн гаргасан төрийн сангийн үйл ажиллагааны эрх зүйн акт нь холбогдох хууль тогтоомжтой нийцэж байна.

1.1.2. ТЕЗ нь Төрийн сангийн үйл ажиллагаатай холбоотой Дотоод хяналт хийх төлөвлөгөөний захирамжаас өөр шийдвэр гаргаагүй байна.

Аймаг сумдын Төрийн сангийн үйл ажиллагааны чиглэлээр гарсан тушаал шийдвэрүүдийг шалгахад 2023-2025 онуудад сумдын төрийн сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийх төлөвлөгөөг баталсан Аймгийн Засаг даргын 2023 оны А/48, 2024 оны А/44, 2025 оны А/33 тоот захирамжуудаас өөр шийдвэр гараагүй байна.

Эдгээр шийдвэрүүд нь Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 3.9.5."Аймаг, нийслэлийн төрийн сан энэ журмын 3.9.3.1-д заасан дотоод хяналт хийх төлөвлөгөөг Засаг даргаар, удирдамжийг санхүү, төрийн сангийн хэлтсийн даргаар тус тус батлуулан мөрдөж ажиллана" гэж заасантай нийцэж байна.

1.2.Төрийн сангийн чиг үүргийг хэрэгжүүлж байгаа албан тушаалтнууд засаг даргын тамгын газарт харьяалагдан үйл ажиллагаагаа явуулж байгаа нь орон нутаг дахь төрийн сангийн хараат бус байдал хангагдахгүй байна.

1.2.1. Аймаг, сумын төрийн сан нь Засаг даргын Тамгын газартаа харьяалагдаж үйл ажиллагаа явуулж байгаа нь төрийн сангийн бодлого тогтолцоо, үйл ажиллагааг хууль эрх зүйд нийцүүлэн бие даан явуулж чадахгүй байх эрсдэлийг дагуулж байна .

Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн бүтэц, орон тоог Сангийн сайдын 2015 оны 90 дүгээр тушаалаар 8 орон тоотой байхаар баталжээ. Төрийн сангийн хэлтэс 2025 оны байдлаар 7 орон тоотой ажиллаж, төрийн сангийн чиг үүргийг хэрэгжүүлж байна. Аймгийн ЗДТГ-ын Салбарын хяналт зохицуулалтын хэлтсийн дарга нь Санхүү төрийн сангийн хэлтсийн даргыг хавсран гүйцэтгэж, орлого хариуцсан мэргэжилтний орон тоонд хүн авч ажиллуулаагүй байна.

Сумдын төрийн санд батлагдсан 48 орон тоонд 44 албан хаагч ажиллаж байгаа бөгөөд Улиастай, Тосонцэнгэл, Цагаанчулуут сумын төрийн сангийн санхүүгийн албаны даргын үүргийн төсөв төрийн сангийн мэргэжилтэн болон сумын ЗДТГ-ын нягтлан бодогч нь хавсран, Тэлмэн сумын төсөв, төрийн сангийн мэргэжилтний албан үүргийг санхүүгийн албаны дарга нь хавсран гүйцэтгэж байна.

Засгийн газрын 2014 оны "Санхүүгийн алба байгуулах тухай" 326 дугаар тогтоолоор сумдын санхүүгийн алба нь албаны дарга, төрийн сангийн мэргэжилтэн, төсвийн нягтлан бодогч 2, татварын байцаагч гэсэн 5 орон тоотой байхаар баталсан ч одоогоор санхүүгийн албаны дарга, төсөв төрийн сангийн мэргэжилтэн гэсэн 2 орон тоотойгоор сумын ЗДТГ-ын харьяанд үйл ажиллагаа явуулж байна.

Аймаг, сумын төрийн сан нь Төсвийн тухай хуулиар Сангийн яаманд төсвийн захирагчийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн мэдээ болон холбогдох бусад тайлан, мэдээллийг хууль, журамд нийцүүлэн хүргүүлэх чиг үүргийг хэрэгжүүлж байгааг тухайн шатны Засаг даргын Тамгын газарт харьяалагдан үйл ажиллагаа явуулж байна.

Энэ нь тухайн төрийн сангийн албан хаагчийн хараат бус байдал алдагдах, төрийн сангийн бодлого тогтолцоо, үйл ажиллагааг хууль эрх зүйд нийцүүлэн явуулж чадахгүй байх эрсдэлийг дагуулж байна.

1.2.2. Сумдын төрийн сангийн албаны дарга, төсөв төрийн сангийн мэргэжилтний гүйцэтгэж буй зарим чиг үүргүүд хоорондоо давхардаж байна.

Аймгийн хэмжээнд төрийн сангийн үйл ажиллагаа, төсөв, мөнгөн хөрөнгө, өр төлбөрийн удирдлагыг хэрэгжүүлэх, төлбөр тооцоог гүйцэтгэх 54 албан хаагч үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Аймаг, сумдын Төрийн сангийн албан хаагчдын гүйцэтгэж буй чиг үүргийг Сангийн сайдын 2015 оны 90 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн санхүү, төрийн сангийн ажилтны ажил үүргийн жишиг заавар”-тай харьцуулан албан тушаалын тодорхойлолтой нийцэж байгаа эсэхийг шалгахад аймгийн төсөв төрийн сангийн хэлтэст ажиллаж байгаа албан хаагчдын хувьд нийцэж байна.

Сумдын санхүү албанд ажиллаж байгаа албан тушаалтнуудын хувьд жишиг заавраар сумын санхүүгийн албаны дарга 26, төсөв, төрийн сангийн мэргэжилтэн 15 албан хаагч чиг үүрэг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Зааварт тусгасан чиг үүргүүдээс доорх заалтууд албан тушаалын тодорхойлолтод тусгагдаагүй байна.

Санхүүгийн албаны дарга буюу төсвийн ерөнхий нягтлан бодогч:

- Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж, төсвийн орлогын давалт, тасралт, зардлын хэтрэлт, хэмнэлтийн шалтгааны талаарх дэлгэрэнгүй тайланг улирал тутам гаргаж дараа сарын 8-ны дотор аймгийн санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлэх.
- Төсвийн гүйцэтгэлийн мэдээг нэгтгэн боловсруулахтай холбогдон хийгдэх залруулгын бичилтийг хийх, өглөг авлагыг бүртгэх,

Төсөв төрийн сангийн мэргэжилтэн:

- Албаны даргын баталсан ажил үүргийн хуваарийн дагуу төсвийн байгууллагын сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг хянан хүлээн авах,
- Төсвийн байгууллагын дансны үлдэгдлийн баталгааг хагас, бүтэн жилээр гаргуулан баталгаажуулах,
- Системд алдаатай бүртгэгдсэн, түр хадгалагдсан гүйлгээг залруулах
- Албаны дотоод ажил хариуцах,
- Сумын төрийн санд шинээр данс нээх, хаах, төсвийн байгууллагын нэр өөрчлөгдөх, бүртгэлтэй байгаа дансыг судалгааг хийн шаардлагагүй дансыг хаалгах зэрэг асуудлыг аймгийн төрийн санд хүргүүлэх,
- Банканд нээгдсэн дансны мэдээллийг үндэслэн сумын болон харьяа төсвийн байгууллагын судалгааг хийн, зөвшөөрөлгүй нээгдсэн дансыг хаалгах арга хэмжээг зохион байгуулах,
- ЗГСУМС-ийн хэрэглэгчийн бүртгэлийг хөтөлж, холбогдох байгууллагад хүргүүлэх гэсэн чиг үүргүүд албан тушаалын тодорхойлолтод тусгагдаагүй байна.

Санхүүгийн албаны дарга болон төсөв, төрийн сангийн мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргүүдийг харьцуулан үзэхэд доорх чиг үүргүүд давхардаж байна. Үүнд:

ТӨРИЙН САНГИЙН ТОГТОЛЦОО, ХУУЛЬ ТОГТООМЖИЙН НИЙЦЭЛ


Хүснэгт №1 Чиг үүргийн давхардлууд

Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Санхүүгийн албаны дарга	Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн
Төсвийн орлого, татварын төлөвлөлт	Татварын орлогын төлөвлөгөөг хянан гүйцэтгэлийг хангуулах, орлогын тогтвортой бааз суурийг судлах чиг үүрэгтэй.	Татварын орлогыг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх, судалгаа гаргах ажилд Татварын албатай хамтран ажиллах үүрэгтэй
Төрийн сангийн гүйлгээ, хяналт	Төрийн сангийн өдрийн гүйлгээний мемориалын баримтыг хянан баталгаажуулж, 1 дүгээр гарын үсэг зурах үүрэгтэй.	Төсвийн байгууллагуудын Төлбөр тооцоог төрийн сангийн журмын дагуу системд бүртгэж, мемориалын баримтыг тулган архивын нэгж үүсгэх чиг үүрэгтэй
Тайлан мэдээ нэгтгэх, хянах	Харьяа байгууллагуудын банкны дансны үлдэгдлийн мэдээг нэгтгэх, төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг боловсруулж дээд шатны байгууллагад хүргүүлэх үүрэгтэй.	Харьяа байгууллагуудын банкны дансны үлдэгдлийн мэдээг нэгтгэх, төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг боловсруулж дээд шатны байгууллагад хүргүүлэх үүрэгтэй.
Мэргэжил арга зүйн зөвлөгөө	Харьяа төсвийн байгууллагуудын нягтлан бодогч нарт мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, хууль тогтоомжийг сурталчлах	Харьяа төсвийн байгууллагуудын нягтлан бодогч нарт мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, хууль тогтоомжийг сурталчлах
Дотоод аудит болон хяналт	Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэмжээнд хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, дотоод аудитыг хэрэгжүүлэх	Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэмжээнд хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, дотоод аудитыг хэрэгжүүлэх

Аймгийн санхүү төрийн сангийн албан хаагчдын хувьд албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлэн чиг үүргийн давхардал байхгүй ажиллаж байна. Харин сумдын төрийн сангийн албан хаагчдын хувьд зарим талаараа чиг үүргүүд нь давхардаж байна.

Төрийн сангийн албан хаагчдаас авсан нэгдсэн судалгаагаар “Таны ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүрэг төрийн сангийн нийтлэг чиг үүрэгтэй нийцдэг үү?” гэсэн асуултад 54 албан хаагчаас 39 албан хаагч бүрэн нийцдэг гэж хариулсан бол 15 албан хаагч нийцдэггүй гэж хариулсан байна.

График № 1. Санал асуулга




Нийцдэггүй ямар чиг үүргүүд байгааг судалж үзэхэд:

- Сумын хэмжээнд төрийн болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулах, тендерийн үнэлгээний хороонд орж ажилладаг нь төлбөр тооцоог хянаж, батлах чиг үүргийг хэрэгжүүлэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэлтэй байна.
- Жендерийн эрх тэгш байдлын тухай хууль, тогтоол, шийдвэр, бодлогын баримт бичиг болон холбогдох үйл ажиллагааны тайлан, мэдээг боловсруулах, нэгтгэн тайлагнах.
- Орон нутгийн статистик мэдээ гаргах, хүн ам, орон сууц, аж ахуйн нэгжийн улсын тооллогын комисст орж ажилладаг гэсэн чиг үүргүүд нь ажлын ачааллыг нэмэгдүүлж байна.

“Ажлын байрны тодорхойлолтод тусгагдаагүй өөр чиг үүргийг хэрэгжүүлдэг үү?” гэсэн асуултад 8 албан хаагч “үгүй” гэж хариулсан бол 46 албан хаагч “тийм” гэж хариулсан байна.

График № 2. Санал асуулга



Ажлын байрны тодорхойлолтод тусгагдаагүй өөр ямар чиг үүргүүд хэрэгжүүлж байгааг судлахад:

- Орон нутагт иргэдийн хувьцааны дансыг нээж өгдөг.
- Статистиктай холбоотой улсын болон орон нутгийн тооллогын ажилд оролцдог.
- Shilen.gov.mn-д төсвийн гүйцэтгэлийн мэдээ мэдээллүүдийг оруулдаг.
- Суманд зохион байгуулж байгаа Тендер худалдан авалтын үнэлгээний хороонд орж ажилладаг гэж хариулт өгсөн байна.

Аудитын илрүүлэлт

Сумдын төрийн сангийн албаны дарга, төсөв төрийн сангийн мэргэжилтний хаагчдын хувьд албан тушаалын гүйцэтгэх 5 чиг үүрэг давхардаж байна.

1.2.3. Системийн үндсэн бүтэц, хэрэглээ нь хэрэглэгчийн хэрэгцээг 98 хувь бүрэн хангаж байгаа боловч, мэдээллийн аюулгүй байдлыг бүрэн шийдэж, "Бусад системтэй автомат холболт хийх" шаардлагатай байна.

Төрийн сангийн цахим системийн ашиглалтын талаарх төрийн сангийн хэрэглэгч буюу хянах, батлах ажилтнаас авсан судалгаагаар нийт 51 оролцогчийн хариултыг нэгтгэн дүгнэхэд дараах байдалтай байна.

Системийн хэрэгцээ хангалт ба давуу тал:

Төрийн сангийн цахим системийн үндсэн үйлдэл, цэс болон ерөнхий бүтэц нь хэрэглэгчдийн өдөр тутмын ажлын шаардлагыг өндөр түвшинд хангаж байна.

Системийн хамгийн том давуу тал нь ажилтнуудад орон зайнаас үл хамааран уян хатан, шуурхай ажиллах боломжийг бүрэн бүрдүүлсэн бөгөөд хэрэглэгчдийн зүгээс системийн нууцлал, өгөгдлийн хамгаалалт, аюулгүй байдалд итгэх итгэл өндөр байна.

Системийн ашиглалтад тулгарч буй хүндрэл, бэрхшээл:

Хэрэглэгчдэд тулгарч буй гол бэрхшээл нь программ хангамж гэхээсээ илүүтэй гадаад орчны дэд бүтэц буюу интернэтийн саатал, цахилгааны тогтворгүй байдлаас шалтгаалж байна. Мөн гүйлгээний ачаалал ихсэх оргил үеэр серверийн гацалт үүсдэг ба анхан шатны баримтад үндэслэн гүйлгээ буцаах үед шалтгаан сонгох агуулга хангалтгүй байдаг нь практик хүндрэлийг үүсгэж байна.

Үүнээс гадна, салбарын хэмжээнд бүрэн цахимжих зорилго тавин ажиллаж байгаа ч хууль эрх зүйн болон хяналтын шаардлагаар зарим гүйлгээний анхан шатны баримтыг цаасан суурьтайгаар давхар хөтлөх, архивлах ажил байсаар байна.

Цаашид сайжруулах чиглэл ба хэрэглэгчдийн санал:

Системийн тасралтгүй, найдвартай ажиллагааг хангахын тулд техник, холбооны нөөц эх үүсвэрийг шийдвэрлэх, ажилтнуудыг чадавхжуулах сургалтыг тогтмолжуулах шаардлагатай байна. Хэрэглэгчдийн зүгээс системийг улам төгс болгохын тулд дараах практик шийдлүүдийг санал болгож байна. Үүнд:

- Шилэн дансны нэгдсэн системтэй цахим хэлбэрээр шууд автомат холболт хийж, өгөгдөл солилцох үйл ажиллагааг автоматжуулах;
- Системд нэвтрэх хэрэглэгчийн нэрийг домэйн хэлбэрт шилжүүлэх замаар аюулгүй байдлыг улам чангатгах;
- Хүний нөөцийн өөрчлөлтийг холбогдох тушаал шийдвэртэй нь уялдуулан системд тусгах;
- Цалин, тэтгэмж тооцоолох дотоод функцуудыг олон сонголттойгоор нарийвчлан нэмэгдүүлэх;

Цаашид системийн найдвартай байдлыг улам бататгахын тулд орчны интернэт хангамж, цахилгааны урсгалыг тогтворжуулах зэрэг дэд бүтцийг сайжруулахын зэрэгцээ төрийн бусад системүүдтэй мэдээлэл солилцох автоматжуулалтыг хийх шаардлагатай байна.

Завхан аймгийн Төрийн сангийн цахим системийн ашиглалт, сэтгэл ханамж, тулгарч буй асуудлуудыг тодорхойлох зорилготой асуулгын үр дүнг нэгтгэн дүгнэхэд дараах байдалтай байна.

Сэтгэл ханамж ба Системийн хэрэглээ:

- Ажилчдын дийлэнх хувь нь өдөр тутмын ажлын хэрэгцээг "бүрэн хангаж байна" эсвэл "хэвийн" гэж үнэлсэн байна. Системийг ашиглахад ойлгомжтой, хялбар гэдэгт бараг бүгд "тийм" гэж хариулжээ.
- Системийн аюулгүй байдал хангагдсан эсэх тал дээр ихэнх нь "тийм" гэсэн боловч "мэдэхгүй" эсвэл "үгүй" гэж хариулсан тохиолдол цөөнгүй байгаа нь аюулгүй байдлын талаарх ойлголт, мэдээллийг ажилчдад илүү өгөх шаардлагатайг харуулж байна.

Тулгарч буй гол бэрхшээлүүд:

Хэдийгээр системийн үндсэн ажиллагаа хэвийн боловч дараах техникийн болон зохион байгуулалтын хүндрэлүүд хамгийн их давтагдаж байна. Үүнд:

- Дэд бүтэц ба сүлжээ: Санал асуулгад оролцогчдын дийлэнх нь "интернэтийн саатал", холболтын хурд муу байгааг хамгийн том асуудал гэж хариулсан байна.
- Программ хангамжийн гацалт: "программ тасалдал" болон "тоног төхөөрөмж"-ийн хоцрогдол, зарим үед систем ачааллаа даахгүй гацах, удаашрах явдал түгээмэл байна.
- Хүний нөөц ба Сургалт: "сургалт хангалтгүй" гэсэн хариулт маш олон гарсан бөгөөд шинэ ажилчид болон сумын төрийн сангийн мэргэжилтнүүдэд чиглэсэн сургалт дутагдаж байгааг дурджээ.

Систем хоорондын уялдаа холбооны тухайд:

- Бусад системүүдтэй мэдээлэл зөв, шууд солилцож чадаж байгаа эсэхэд "үгүй" эсвэл системээс үүссэн асуудлыг шийдвэрлэхэд "удаашралтай" гэсэн хариултууд нэлээдгүй хувийг эзэлж байна.
- Ажилтнуудын зүгээс бусад санхүүгийн болон татварын программ, байгууллагын дотоод системүүдтэй уялдаа холбоог сайжруулах, нэгтгэх шаардлагатай байна.

Нээлттэй асуултын хэсэгт дараах гол саналуудыг тусгасныг дурдвал:

- Цахим шилжилтийг бүрэн хийх: Цаасан хэрэглээг бүрэн халах, шивсэн гүйлгээг заавал дахин хэвлэж баталгаажуулдаг чирэгдлийг зогсоох.
- Холболт ба Уялдааг сайжруулах: ХХОАТ-ын ТАЦНС, Санхүүгийн бусад порталуудтай шууд холбодог болгох, дата зөрүүг арилгах.
- Дэмжлэг үзүүлэх: Системд алдаа засах, шинэчлэлт хийх үйл явцыг хурдан шуурхай болгох, тусламж авах холбоо барих утас, хэрэглэгчийн дэмжлэгийг тодорхой болгох.
- Сургалт зохион байгуулах: Цахим сургалтуудыг тогтмолжуулж, систем ашиглах зааварчилгааг илүү ойлгомжтой болгох.

Завхан аймгийн Төрийн сангийн цахим систем нь хэрэглэгчдийн хувьд ашиглахад хялбар, үндсэн хэрэгцээг хангаж байгаа хэдий ч интернэтийн хурд, системийн гацалт тасалдал, систем хоорондын уялдаа холбоо сул байгаа нь ажлын бүтээмжид сөргөөр нөлөөлж байна.

Цаашид системийн шинэчлэлтийг цаг тухайд нь шуурхай хийх, техникийн дэмжлэг үзүүлэх явцыг хурдасгах, болон мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтуудыг тасралтгүй зохион байгуулах шаардлагатай байна.

2.ТӨРИЙН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ӨДӨР ТУТМЫН ХЯНАЛТ СУЛ БАЙГААГААС ТӨРИЙН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА

2.1. Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийг батлагдсан төсөв, төсвийн хуваариар, журамд заасан хугацаандаа олгохгүй байгаа нь Сангийн яамнаас олгож байгаа санхүүжилт тухайн сарын 5-8-ны хооронд олгогдож байгаагаас шалтгаалжээ.

2.1.1. Төсвийн санхүүжилтийг батлагдсан төсвийн хуваариас зөрүүтэй, журамд заасан хугацааг баримтлахгүй, хоцроож олгож байна.

Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.8, Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 2.6-д заасны дагуу орон нутгийн төсөвт байгууллага болон сумдын санхүүжилтийн эрхийг журмын хавсралт маягт 23-аар, батлагдсан төсвийн хуваариар олгохоор заасан байна.

Санхүүжилтийн эрхийг Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 2.6.1-д заасан хугацаанд нь олгосон эсэхийг 2023-2025 онуудыг хамруулан аймгийн ТЕЗ-ийн санхүүжилт олгосон нийт 690 байгууллагын батлагдсан төсвийн хуваарийг, байгууллагуудын дансны хуулгатай тулгахад батлагдсан төсвөөс 4,027.7 сая төгрөгөөр илүү, 15,503.2 сая төгрөгөөр дутуу олгосон байна.

Санхүүжилтийн эрхийг, журмын 2.7.1.-д “Төв төрийн сан нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан улсын төсвийн болон Засаг даргын баталсан орон нутгийн төсвийн хуваарийн дагуу зарцуулалтын эрхийг тухайн сарын ажлын эхний 5 өдрийн дотор олгоно” гэж заасан хэдий ч аймгийн хувьд Сангийн яамнаас хуваарилсан төсөв тухайн сарын хэдэнд орж ирж байгаагаас шалтгаалан хугацаандаа санхүүжилтийн эрхийг олгох боломжгүй байна.

2.1.2. Төсвийн хөрөнгө оруулалттай холбоотой дансны зарцуулалтын эрхийг нээхдээ журам зөрчин нээж байгаа нь төсвийн зарцуулалтад тавих хяналтыг сулруулж байна

Орон нутгийн төсвийн санхүүжилтийн эрх олгох

Аймгийн төрийн сангийн төсөв хариуцсан мэргэжилтэн нь аймаг сумдын байгууллагуудын төсвийн хуваарийн дагуу зарцуулалтын эрх нээж байгаа бөгөөд 2025 оны зарцуулалтын эрх нээсэн байдлыг санхүүжилттэй тулгахад, төрийн сангийн төсвийн зарцуулах эрхийг эдийн засгийн ангилал болон шаардлагад нийцүүлэн нээсэн байна.

Төрийн сангийн үйл ажиллагааны журамд заасан хугацаанд төсөвт байгууллагуудын санхүүжилтийн эрхийг сар бүрийн ажлын эхний 5 хоногт багтаан олгоно гэж заасан ч сумдын санхүүжилтийн эрхийг сар бүрийн 10-аас хойш нээж байгаа нь Сангийн яамнаас аймагт хуваарилах орлогыг ихэвчлэн сар бүрийн төсвийн мэдээ татсанаас хойш буюу 5-8-ны өдрүүдэд хуваарилж байгаатай холбоотой байна.

Нэмэлт төсвийн зарцуулалтын эрх олгох

2023-2025 онуудад ТЕЗ-ийн харьяа болон төсөвт байгууллагуудын нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсөв захирагч, үндсэн үйл ажиллагааны хүрээнд нийт 22,052.7 сая төгрөгийн орлого бүрдүүлжээ.

ТӨРИЙН САНГИЙН ТОГТОЛЦОО, ХУУЛЬ ТОГТООМЖИЙН НИЙЦЭЛ

Үүнээс цалин, нийгмийн даатгалын шимтгэл, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хангамж, бараа материал, эд хогшил урсгал засвар, дотоод албан томилолт, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж, бараа үйлчилгээний бусад зардал, нэг удаагийн тэтгэмж урамшуулал зэрэг урсгал зардалд 19,836.6 сая төгрөгийг зарцуулж, зарцуулагдаагүй үлдэгдэл 3,174.9 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна

Хүснэгт №2 Нэмэлт санхүүжилтийн төсвийн мэдээ

Он	Нэмэлт санхүүжилтийн дансны эхний үлдэгдэл	Нэмэлт санхүүжилтийн дансны орлого	Нэмэлт санхүүжилтийн дансны зарлага	Төвлөрүүлэг шилжүүлэг
2023	958.8	6,410.5	6,116.1	1,253.20
2024	-	9,419.6	8,362.1	1,057.5
2025	-	6,222.6	5,358.4	864.2
Нийт		22,052.7	19,836.6	3,174.9

Аудитаар аймгийн төсвийн байгууллагуудын 2023-2025 онд нэмэлт төсвийн зарцуулалтын эрх нээлгэх хүсэлтээс түүвэрлэн 799 байгууллагад эрх олгосон байдлыг шалгалаа.

Давхардсан тоогоор 799 байгууллагад нэмэлт санхүүжилтийн 16,088.8 сая төгрөгийн эрхийг байгууллагуудаас ирүүлсэн хүсэлтийн дагуу хөтөлбөр, зориулалт, эдийн засгийн ангиллын дагуу нээсэн байна.

Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 2.12.2-т "Төсвийн байгууллага нь нэмэлт төсвийн зарцуулалтын эрх нээлгэх хүсэлтийг дараах баримт бичгийн хамт цахимаар, эсхүл албан бичгээр харьяалагдах төрийн санд хүргүүлнэ" гэж заасны дагуу эрх нээлгэхэд шаардагдах баримтуудаас зарцуулалтын эрхийн хүсэлт, албан тоот, төсвийн захирагчийн шийдвэр болон бусад холбогдох шийдвэрүүдийг үндэслэж зарцуулалтын эрх нээх ёстой байтал зөвхөн албан тоот эсвэл журмын 32 дугаар хавсралтаар зарцуулалтын эрх нээсэн 92 байгууллагын 984.7 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь журмын 2.12.3-т "Төрийн сан нь энэ журмын 2.12.2-т заасан шаардлагыг хангасан төсвийн байгууллагын хүсэлтийг хянаж, ажлын 3 өдрийн дотор зарцуулах эрхийг олгоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн зардлын эрх олгох:

Тайлант онуудад аймгийн барьцаа хөрөнгийн дансанд гүйцэтгэгчээс суутган шилжүүлсэн 10,893.2 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, барьцааг чөлөөлсөн зардал болон бусад зардлын 9,048.2 сая төгрөгийн гүйлгээ хийсэн байна.

Хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн зардлын зарцуулалтын эрхийг нээхдээ журмыг баримталж нээсэн эсэхийг хянахад 2023-2025 онуудад орон нутгийн төсвөөр хэрэгжих хөрөнгө оруулалтын ажлыг санхүүжүүлсэн, урсгал зардлын гүйлгээний эрх нээсэн, барьцааг чөлөөлөх хугацаа болоогүй байхад эрх нээж барьцаа хөрөнгийг чөлөөлсөн 685.5 сая төгрөгийн 14 гүйлгээний эрхийг нээж санхүүжүүлсэн байгаа нь журмын 2.9.1-д заасан төрийн сан нь хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн зардлын эрхийг төсвийн захирагч буюу захиалагчийн шийдвэр, хууль болон гэрээнд заасан холбогдох заалтыг үндэслэн олгоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Захиалагчийн хяналтын зардлын эрх олгох:

2023-2025 онд аймгийн хөрөнгө оруулалтын техник хяналтын дансанд 4,240.9 сая төгрөг ажил гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдээс төвлөрч, 3,076.4 сая төгрөгийг техник хяналтын болон бусад зардалд зарцуулсан байна.

Төрийн сан зарцуулалтын эрхийг нээхдээ, журамд заасан зардлуудын санхүүжүүлэх эрх нээсэн эсэхийг хянаж үзэхэд 2023-2025 онуудад нийт зориулалт бус зардлын 86 гүйлгээний 982.2 сая төгрөгийн зарцуулалтын эрхийг олгосон байна.

Энэ нь журмын 2.10.1 “Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа хөрөнгө оруулалтын ажилд захиалагчийн хяналт хийхтэй холбогдон гарах томилолт, тээвэр шатахуун, шуудан холбоо, бичиг хэрэг, гэрээгээр гүйцэтгүүлэх хяналтын зардал, хяналт хийхэд шаардлагатай хэмжих шалгах багаж хэрэгсэл болон бусад зардлыг санхүүжүүлнэ” гэж заасныг зөрчсөн байна.

Аудитын илрүүлэлт

- Нэмэлт санхүүжилтийн зарцуулалтын эрхийг нээхдээ 92 байгууллагын 984.7 сая төгрөгийн санхүүжилтийн эрхийг журмыг зөрчин нээсэн байна.
- Захиалагчийн хяналтын зориулалт бус 86 гүйлгээний 982.2 сая төгрөгийн зарцуулах эрхийг нээсэн байна
- Барьцаа хөрөнгийн дансны орон нутгийн төсвөөр хэрэгжих хөрөнгө оруулалтын ажлыг санхүүжүүлсэн, урсгал зардлын гүйлгээний эрх нээсэн, барьцааг чөлөөлөх хугацаа болоогүй байхад эрх нээж барьцаа хөрөнгийг чөлөөлсөн 685.5 сая төгрөгийн 14 гүйлгээний эрхийг нээсэн байна.

2.2 Төрийн сангийн, төлбөр тооцооны үйл ажиллагаа хууль, журмын дагуу хэрэгжиж байгаа боловч зарим гүйлгээнд анхан шатны баримтын бүрдэл дутуу, эдийн засгийн ангилал зөрчсөн гүйлгээ болон дансны үлдэгдлийг хянаж баталгаажуулаагүй, зөрчлүүд илэрч байна.

2.2.1. Аймаг, сумдын төрийн сан дансны үлдэгдлээ төсвийн байгууллагуудтай тулгадаг хэдий ч хагас жил тутмын тооцооны үлдэгдлийн баталгаажуулалт тогтмолжоогүй байна.

Төрийн сангийн үлдэгдлийн тулгалт:

Аймаг, сумдын төрийн сангийн болон төсвийн байгууллагуудын данс 2023 онд 14,862.6 сая төгрөг, 2024 онд 17,585.6 сая төгрөг, 2025 онд 2,251.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аймгийн төрийн сан болон сумдын 19 төрийн сангийн холбогдох албан хаагчдаас авсан судалгаагаар төсвийн байгууллагуудын 15 сум буюу 80 хувь нь дансны үлдэгдлийн баталгааг жил бүр тогтмол үйлддэг, 4 сум буюу 20 хувь нь огт үйлддэггүй гэж хариулсан байна.



Төсвийн байгууллагуудын дансны үлдэгдлийг тулган баталгаажуулах явцад зөрүү гарвал тухай бүр залруулах арга хэмжээг авч ажилладаг байна.

2.2.2. Аймаг, сумдын Төрийн сан, төсвийн байгууллагууд төсвийн хөрөнгийг анхан шатны баримт, зохих шийдвэр, зөвшөөрөлгүйгээр буюу зориулалтын бусаар зарцуулсан зөрчил гаргажээ.

Аймаг, сумдын төрийн сангийн 2023-2025 оны 05 дугаар сар болон 12 дугаар сарын 01-31-ний өдрүүдэд хийгдсэн 50.0 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй нийт 11,735.4 сая төгрөгийн 94 гүйлгээг түүвэрлэн шалгахад дараах зөрчлүүд илэрлээ

- Төлбөрийн мэдэгдэлд эрх бүхий албан тушаалтны гарын үсэггүй, ажил гүйцэтгэх болон халаалтын гэрээ хавсаргаагүй, ИТХ-ын тогтоол, төсвийн хэлбэлзэл, байгууллагын албан хүсэлт зэрэг үндэслэх баримт дутуу байхад гүйлгээг хянаж баталгаажуулдаг.
- Нэр дансны зөрүүтэй ангиллаар гүйлгээ гаргасан, орлогын дэлгэрэнгүй хуулгагүй шилжүүлэг хийдэг.
- Сумдын орлогын төвлөрүүлэг шилжүүлгийн гүйлгээнд ИТХ-ын тогтоол, төсвийн хэлбэлзэл хавсаргаагүй байхад гүйлгээг баталдаг.
- Нэг төрлийн зөрчил олон удаа давтагдсан, төрийн сангийн хяналтын шатанд баримт нягтлахгүй байгаа зэрэг нь Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 3.4.10-т “Төрийн сан төсвийн байгууллагын төлбөрийн хүсэлтийг төлбөр гүйцэтгэхэд үндэслэх санхүүгийн анхан шатны баримттай тулган, батлагдсан төсвийн зарцуулалтын эрх, хөтөлбөр, зориулалт, арга хэмжээ, эдийн засгийн ангилал, ирүүлсэн мэдээлэлд үндэслэн ажлын 3 өдрийн дотор төлбөрийг гүйцэтгэх ба шаардлага хангаагүй тохиолдолд гүйлгээг буцаана” гэж заасантай нийцэхгүй байна.

ТӨРИЙН САНГИЙН ТОГТОЛЦОО, ХУУЛЬ ТОГТООМЖИЙН НИЙЦЭЛ

*Хүснэгт №3 Зөрчлийн дэлгэрэнгүй
/сая.төгрөг/*

№	Гүйлгээний утга	Мөнгөн дүн	Хаанаас шилжсэн	Хэнд шилжсэн	Хяналтын хуудаст дутуу байршуулсан баримтууд
1	Аймгийн НЭ-ийн зүүн талд авто зогсоол хийх ажлын санхүүжилт	54.9	Аймгийн төрийн сан 100090051000	“Манант оргил” ХХК	Төлбөрийн мэдэгдэлд эрх бүхий албан тушаалтны гарын үсэггүй
2	Отгон сум соёлын төвийн засварын ажлын санхүүжилт	170.5	Аймгийн төрийн сан 100090051300	“Би би Ди Эм” ХХК	Төлбөрийн мэдэгдэлд эрх бүхий албан тушаалтны гарын үсэггүй
3	Сумын хөгжлийн төлөвлөгөө эхний санхүүжилт олгов	50.8	Сонгино сумын ОНХС 100091652400	Циркулпроект ХХК	Ажил гүйцэтгэх гэрээ
4	Завхан орлого төвлөрүүлэв	322.7	За.Цэргийн дүйцүүлэх алба 100090000983	Цэргийн дүйцүүлэх алба 100900000704	Тухайн байгууллагын албан тоот хүсэлтгүй, нэр данс зөрүү ангиллаас гаргасан.
5	Завхан аймгийн Их-Уул сумын ЕБС Түлш халаалтын төлбөр	162.2	За.Их-Уул 11 жилийн сургууль 100090815101	Ханжаргалант стоунс ХХК	Халаалтын гэрээ
6	Чадварлаг эмч хөтөлбөрийн санхүүжилт	420.0	За.ОНХСан 100090052400	Аймгийн ЭМГ 100090020403	Төлбөрийн мэдэгдэлд эрх бүхий албан тушаалтны гарын үсэггүй
7	2-р сургуулийн спорт заалны дээвэр засварлахад шаардагдах барилгын мат	53.9	За.ОНХСан 100090052400	Тосонцэнгэл сумын ЗДТГ 100090455405	Төлбөрийн мэдэгдэлд эрх бүхий албан тушаалтны гарын үсэггүй
8	Завхан аймгийн УСЗДТГ авто машин үнэ	85.7	Улиастай сумын ЗДТГ 100091750405	Солонгос улсаас авто машин нийлүүлэгчдийн холбоо	Ажил гүйцэтгэх гэрээ
9	АУЭХС 1-4 сар залруулав /Завхан аймгийн Улиастай сумын/	96.0	Улиастай сумын төрийн сан 100091700910	Улиастай сумын төрийн сан 100091700901	Орлогын дэлгэрэнгүй хуулгыг
10	Хүнгий голын Ногоон хэрэм төслийн урьдчилгаа санхүүжилт	60.0	Завханмандал сумын ЗДТГ 100090655402	Нугын бэлчир ХХК	Ажил гүйцэтгэх гэрээ
11	Төвлөрүүлэлт /Завхан аймгийн Улиастай сумын төрийн сан/	1,623.0	Улиастай сумын төрийн сан 100091752100	Завхан аймаг санхүү төрийн сангийн хэлтэс 100090000910	Аймаг, сумын ИТХ-н тогтоол
12	Тэс сумаас аймагт төвлөрүүлэв	77.1	Тэс сумын төрийн сан 100091452100	Завхан аймаг санхүү төрийн сангийн хэлтэс 100090000910	Төсвийн хэлбэлзэл
23	Ямаан усны археологийн судалгааны ажлын санхүүжилт	100.0	За.ОНХСан 100090052400	Борх ямаан ус ХХК	Төлбөрийн мэдэгдэлд эрх бүхий албан тушаалтны гарын үсэггүй
14	Баяр наадмын талбайн санхүүжилт	80.0	За.Тосонцэнгэл ОНХСан 100090452400	Зост-өргөө ХХК	Ажил гүйцэтгэх гэрээ

ТӨРИЙН САНГИЙН ТОГТОЛЦОО, ХУУЛЬ ТОГТООМЖИЙН НИЙЦЭЛ

15	Төвлөрүүлэх орлого Завхан Тосонцэнгэл сумын төрийн сан	406.8	Тосонцэнгэл сумын төрийн сан 100090452100	Завхан аймаг санхүү төрийн сангийн хэлтэс 100090000910	Аймаг, сумын ИТХ-н тогтоол
----	--	-------	---	--	----------------------------

Аудитын илрүүлэлт:

Төрийн сангийн 2023–2025 оны 05 дугаар сар болон 12 дугаар сарын гүйлгээнээс 50.0 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй 94 гүйлгээний 11,735.4 сая төгрөгийн мэдээллийг түүвэрлэн шалгахад өдөр тутмын хяналт сул байгаагаас баримт дутуу гүйлгээг баталгаажуулсан 3,556.0 сая төгрөгийн 26 зөрчил илэрлээ.

Төрийн сан зарлагын гүйлгээг журамд заасан хугацаанд хаасан байдал:

1. Төсвийн жилийн эцэс:

Аймаг, сумдын төрийн сан нь Монгол Улсын 2024, 2025 оны төсвийн жил дуусгавар болж байгаатай холбогдуулан төсвийн байгууллагуудын бүртгэлийн дансны зарлагын гүйлгээг Төрийн сангийн удирдлагын цахим системээр хянах, баталгаажуулах эрхийг 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 15:00 цагт, 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 15:00 цагт тус тус хаах талаар Төв төрийн сангаас өгсөн боловч чиглэлийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй байна.

Тухайн хугацаанаас хойш илгээгдсэн гүйлгээг хянан үзэхэд дараах байдалтай байна.

Хүснэгт №4 Төсвийн жилийн хугацаанаас хойш илгээгдсэн

Тайлант он	Нийт гүйлгээ (тоо)	Нийт гүйлгээний мөнгөн дүн (сая төгрөг)	Илгээсэн гүйлгээ (тоо)	Илгээсэн гүйлгээний мөнгөн дүн (сая төгрөг)	Буцаасан болон цуцлагдсан гүйлгээ (тоо)	Буцаасан болон цуцлагдсан гүйлгээний мөнгөн дүн (сая төгрөг)
2024	69	129.4	64	122.0	5	7.4
2025	512	2,093.2	461	1,966.3	51	126.9
Нийт	581	2,222.6	525	2,088.3	56	134.3

2024 онтой харьцуулахад 2025 онд хугацаа хэтрүүлэн илгээсэн гүйлгээний тоо 69-өөс 512 болж, 443 гүйлгээгээр нэмэгдэж, мөнгөн дүнгийн хувьд 129.4 сая төгрөгөөс 2,099.2 сая төгрөг болж, 1,963.8 сая төгрөгөөр өссөн байна.

Энэхүү өсөлт нь зөвхөн гүйлгээний тооноос гадна их хэмжээний мөнгөн дүнтэй гүйлгээнүүд хугацаа хэтэрч илгээгдсэн байна. Энэ нь Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 444 дүгээр тогтоолын хавсралт “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.5.8-д “Төрийн сан нь сар бүрийн эцсийн ажлын өдөр 14 цагт зарлагын гүйлгээг хаана” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Дээрх нөхцөл байдал нь төсвийн жилийн хаалтын үед тавих хяналт сул, өгсөн чиглэлийн хэрэгжилт хангалтгүй, мөн дотоод зохион байгуулалт, шаардлагатай түвшинд хэрэгжээгүй байна.

Аудитын илрүүлэлт:

Аймаг, сумдын төрийн сан төсвийн жилийн хаалттай холбоотойгоор төсвийн байгууллагуудын зарлагын гүйлгээг хянах, баталгаажуулах эрхийг тогтоосон хугацаанд хаах чиглэлийг бүрэн хэрэгжүүлээгүй байна. Үүний улмаас эрх хаагдсан хугацаанаас хойш 2024 онд 122.0 сая төгрөгийн 64 гүйлгээ, 2025 онд 1,966.3 сая төгрөгийн 461 гүйлгээг тус тус шилжүүлсэн зөрчил илэрлээ.

2. Сар бүрийн эцсийн ажлын өдрийн гүйлгээ:

Аймаг, сумын төрийн сан нь сар бүрийн эцсийн ажлын өдрийн 14:00 цагт зарлагын гүйлгээг хаах журмыг мөрдөөгүйгээс тухайн хугацаанаас хойш гүйлгээ илгээсэн зөрчил гарсан байна.

Хүснэгт №5 Сарын бүрийн эцсийн ажлын өдрийн хугацаанаас хойш илгээгдсэн

Тайлант он	Нийт гүйлгээ (тоо)	Нийт гүйлгээний мөнгөн дүн (сая төгрөг)	Илгээсэн гүйлгээ (тоо)	Илгээсэн гүйлгээний мөнгөн дүн (сая төгрөг)	Буцаасан болон цуцлагдсан гүйлгээ (тоо)	Буцаасан болон цуцлагдсан гүйлгээний мөнгөн дүн (сая төгрөг)
2024	673	1,727.8	572	1,207.1	101	520.7
2025	1025	2,221.3	899	2,067.7	126	153.6
Нийт	1698	3,949.1	1471	3,274.8	227	674.3

Хугацаа хэтэрсэн гүйлгээ 2024 онд 1,727.8 сая төгрөгийн дүнтэй 673 удаа хийгдсэн бол 2025 онд гүйлгээний тоо 1,025 болж 352-оор, мөнгөн дүн 2,221.3 сая төгрөг болж 493.5 саяар тус тус өссөн байна.

Мөн илгээсэн гүйлгээний тоо 2024 онд 572 байсан бол 2025 онд 899 болж 327 гүйлгээгээр нэмэгдсэн бөгөөд мөнгөн дүн нь 1,207.1 сая төгрөгөөс 2,067.7 сая төгрөг болж 860.6 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь хугацаа хэтрүүлэн илгээсэн гүйлгээ тогтмол нэмэгдэж байгааг харуулж байна.

Харин буцаасан болон цуцлагдсан гүйлгээний тоо 101-ээс 126 болж өссөн боловч мөнгөн дүн нь 520.7 сая төгрөгөөс 153.6 сая төгрөг болж 367.1 сая төгрөгөөр буурсан байна. Энэ нь 2025 онд буцаагдсан гүйлгээний тоо нэмэгдсэн ч өмнөх оноос харьцангуй бага дүнтэй гүйлгээнүүд буцаагдсан болохыг илтгэж байна.

Аймаг, сумын төрийн сан сар бүрийн эцсийн ажлын өдрийн 14:00 цагт зарлагын гүйлгээг хаах журмыг мөрдөөгүйгээс хугацаа хэтрүүлэн гүйлгээ илгээх зөрчил 2025 онд өмнөх оноос нэмэгдсэн байна. Ялангуяа нийт гүйлгээний тоо болон мөнгөн дүн өссөн нь хугацааны хяналт, дотоод зохион байгуулалт, хариуцлагын хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна. Энэ нь Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 444 дүгээр тогтоолын хавсралт “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.5.7-д “Төсвийн жилийн эцэст төрийн сан нь төсвийн байгууллагын урсгал зарлагын гүйлгээг Монгол банкны банк хоорондын гүйлгээ хаах өдрөөс ажлын 3 өдрийн өмнөх өдрийн 12 цагт хаана” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Аудитын илрүүлэлт:


Аймаг, сумын төрийн сан нь сар бүрийн эцсийн ажлын өдрийн 14:00 цагт зарлагын гүйлгээг хаах журам, чиглэлийг бүрэн хэрэгжүүлээгүй байна. Үүний улмаас хаалтын хугацаанаас хойш 2024 онд 1,207.1 сая төгрөгийн 572 гүйлгээ, 2025 онд 2,067.7 сая төгрөгийн 899 гүйлгээг тус тус шилжүүлсэн зөрчил илэрлээ.

2.2.3. Сумдын бүртгэлийн дансны тодорхойгүй орлогын буцаалтын залруулгыг хийхдээ нийт 118.2 сая төгрөгийн гүйлгээг хууль тогтоомжид заасны дагуу холбогдох баримтыг үндэслэн бүрэн баталгаажуулаагүй байна.

Тодорхой бус орлогын залруулга хийхдээ нотлох баримтад үндэслэсэн байдал:

Сумдын бүртгэлийн дансанд орсон 511.6 сая төгрөгийн тодорхойгүй гүйлгээг шилжүүлэхдээ, дансны нэр болон дугаар зөрсөн тохиолдолд банк, байгууллага эсвэл иргэнээс ирүүлсэн бичгээрх хүсэлтийг үндэслэн өөр данс руу шилжүүлдэг байна. Харин 118.2 сая төгрөгийн гүйлгээг хийхдээ шаардлагатай анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлээгүй байна.

График № 4. Тодорхойгүй гүйлгээ, анхан шатны баримт бүрдүүлэлт



Тодорхойгүй орлогын дүн 2023 онд 39.4 сая төгрөг байсан бол 2024 онд 259.0 сая төгрөг болж огцом өссөн байна. Орлогын зориулалт, эх үүсвэр тодорхойгүй гүйлгээ их хэмжээгээр нэмэгдсэнийг харуулж байна. Харин 2025 онд 213.2 сая төгрөг болж буурсан хэдий ч өндөр түвшинд байна.

Хүснэгт №5 Тодорхойгүй гүйлгээ

Тайлант он	2023 он			2024 он			2025 он	
Тодорхойгүй орлого	39.4			259			213.2	
Анхан шатны баримт хангалтгүй	8.7			81.9			27.6	
Зөрчилтэй сумд	Улиастай	бусад 9 сум	Тосонцэнгэл	Их-Уул	Эрдэнэхайрхан	бусад 7 сум	Тосонцэнгэл	бусад 17 сум
	3.8	4.9	17.4	22.8	31.1	10.6	15.5	12.1

Мөн анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй гүйлгээ 2023 онд 8.7 сая төгрөг байсан бол 2024 онд 81.9 сая төгрөг болж өссөн байна. Энэ нь гүйлгээ хийхдээ шаардлагатай баримт, хүсэлт, нотлох материал дутуу бүрдүүлсэн тохиолдол нэмэгдсэнийг илтгэж байна. 2025 онд уг үзүүлэлт 27.6 сая төгрөг болж буурсан боловч баримтын бүрдлийг сайжруулах шаардлагатай байна.

Аудитын илрүүлэлт:

Тайлант хугацаанд сумдын бүртгэлийн дансны тодорхойгүй орлогын буцаалтын залруулгыг хийхдээ нийт 118.2 сая төгрөгийн гүйлгээний анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлээгүй зөрчил илэрлээ.

Татварын орлогын залруулга, буцаалт:

Татвар төлөгчийн 2022-2024 оны хүлээн авч баталгаажсан албан татварын тайлан, татвар төлөгчийн илүү төлөлтөө буцаан авах хүсэлтийг үндэслэн Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.14-д “Албан татварын хөнгөлөлтийг энэ хуульд заасан эцсийн хугацаанд тайлагнаж төлсөн албан татварын дүнгээс хэтрүүлэн эдлүүлэхгүй бөгөөд энэ хуулийн 23.1, 23.9-д зааснаас бусад албан татварын хөнгөлөлтийг 28 дугаар зүйлд заасны дагуу буцаан олгоно” гэж заажээ.

Сумдын төрийн сангийн данснаас аймгийн төрийн санд 3,839.2 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Тус гүйлгээг хийхдээ аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, төсвийн хэлбэлзэл зэргийг хавсаргаагүй, нотлох баримт хангалтгүй гүйлгээнүүд хийсэн байна. Үүнээс 2023-2025 онуудад Баянхайрхан, Нөмрөг, Сонгино, Түдэвтэй, Тэс, Цагаанхайрхан, Цагаанчулуут, Яруу сумдын төрийн сан 687.8 сая төгрөгийн 21 гүйлгээ хийхдээ зардлын эдийн засгийн ангилал зөрчсөн байна.

/сая.төгрөг/			
№	Код	Зардлын ангиллын нэр	Мөнгөн дүн
1	010001	Төрийн сан дахь МХ-ийн С1	60.4
2	110001	Цалин, түүнтэй адилтгах	564.3
3	110002	Үйл ажиллагааны орлого	51.8
4	300015	Нэр данс зөрүү	11.3

Аудитын илрүүлэлт:

2023-2025 онуудад 8 сумын Төрийн сан ХХОАТ-ын буцаан олголтын 687.8 сая төгрөгийн 21 гүйлгээг зардлын эдийн засгийн ангилал зөрчин гүйцэтгэсэн зөрчил илэрлээ.

2.2.4. Төсвийн гүйцэтгэлийн тайлан, тооцоог холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хугацаанд нь, иж бүрэн боловсруулж тайлагнаагүй байна.

Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс нь нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайланг хуулийн хугацаанд нь буюу жил бүрийн 3 дугаар сарын 1-ний дотор Сангийн яам болон Завхан аймаг дахь Төрийн аудитын байгууллагад хүргүүлж ажилласан байна.

Төсвийн тохируулга ба анхан шатны баримтын бүрдэл:

Орон нутгийн хөгжлийн сан болон тусгай зориулалтын шилжүүлгээр аймаг, сум хооронд төсвийн тохируулга хийх шатанд Сантмаргац, Дөрвөлжин, Шилүүстэй сумдын Төрийн сангууд авлага, өрийн зөрүүг баталгаажуулсан "Тооцоо нийлсэн акт"-ыг цахим системд хавсаргалгүйгээр тохируулгын бичилтүүдийг шууд хийсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нь нягтлан бодох бүртгэлийг анхан шатны баримтад үндэслэн хөтөлнө", 7.4-т "Анхан шатны баримтгүйгээр нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, тайланд ажил гүйлгээг тусгахыг хориглоно" гэж заасныг тус тус зөрчиж байна.

Төсвийн гүйцэтгэлийг батлах хуулийн хэрэгжилт:

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь хуулиар хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна. Тодруулбал:

- Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.3-т "Төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэн батлах",
- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.9-д "Засаг даргын өргөн мэдүүлснээр тухайн аймаг, сум, нийслэл, дүүргийн төсвийг хэлэлцэж батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гүйцэтгэлийг батлах" гэж заасан байдаг. Хэдийгээр хуульд ингэж заасан ч аймгийн ИТХ-аас төсвийн гүйцэтгэлийг эцэслэн баталдаггүй байна.

Сарын мэдээний хяналт ба баталгаажуулалт:

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.8.1 болон Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 4.7.1-д зааснаар төсвийн байгууллагууд сарын гүйцэтгэлийн мэдээгээ дараа сарын 02-ны дотор харьяалах төсвийн захирагчид хүргүүлэх үүрэгтэй

Аудитаар 2023-2025 оны төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг шалгахад аймаг, сумдын Төрийн сангууд мэдээг тогтмол хянан баталгаажуулж хэвшсэн сайн тал байгаа ч дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Төрийн сангийн мэргэжилтнүүд мэдээг хүлээн авсан огноогоо тухай бүр тэмдэглэдэггүйгээс шалтгаалж, тайланг хугацаандаа ирүүлсэн эсэхийг тодорхойлох боломжгүй байна.
- Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулаагүй, хүчин төгөлдөр бус сарын мэдээг шууд хянан баталгаажуулсан байна

2.3.Төрийн сангийн үйл ажиллагаанд, өдөр тутмын хяналтын тогтолцоог үр нөлөөтэй хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2.3.1.Дотоод хяналтаар төрийн сангуудад өгсөн зөвлөмжийн биелэлтийн хэрэгжилтийг тооцоогүй, холбогдох арга хэмжээг авч ажиллаагүй байна.

Төрийн сангийн дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.6, Сангийн сайдын 2024 оны 254 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журам”-ын дагуу хэрэгжүүлэхдээ эрсдэлийг үнэлэн өдөр тутмын төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус гэсэн хяналтуудыг хэрэгжүүлнэ гэж заасан байна.

Аймгийн төрийн сангийн дотоод хяналт нь 2023-2025 онд аймгийн Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн А/48, 2024 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн А/44 , 2025 оны 02 дугаар сарын А/34 тоот захирамжаар 22 сумын төрийн санд дотоод хяналтыг зохион байгуулах төлөвлөгөө батлуулсан байна.

ТӨРИЙН САНГИЙН ТОГТОЛЦОО, ХУУЛЬ ТОГТООМЖИЙН НИЙЦЭЛ

Хүснэгт 6 Төрийн сангаас 2023-2025 онд хэрэгжүүлсэн төлөвлөгөөт хяналтын талаарх мэдээлэл

№	Хяналтад хамрагдсан нэгж	Эрсдэлийн түвшин	Өгсөн зөвлөмжийн тоо	Зөвлөмжийн биелэлт
2023 он				
1	Алдархаан сумын Төрийн сан	Дунд	18	Ирүүлээгүй
2	Их-Уул сумын Төрийн сан	Дунд	16	Ирүүлээгүй
3	Тосонцэнгэл сумын Төрийн сан	Дунд	17	Ирүүлээгүй
4	Түдэвтэй сумын Төрийн сан	Дунд	12	Ирүүлээгүй
5	Тэс сумын Төрийн сан	Дунд	16	Ирүүлээгүй
6	Сонгино сумын Төрийн сан	Дунд	14	Ирүүлээгүй
7	Цагаанхайрхан сумын Төрийн сан	Дунд	16	Ирүүлээгүй
8	Цагаанчулуут сумын Төрийн сан	Дунд	18	Ирүүлээгүй
9	Цэцэн-уул сумын Төрийн сан	Дунд	14	Ирүүлээгүй
10	Шилүүстэй сумын Төрийн сан	Дунд	29	Ирүүлээгүй
11	Эрдэнэхайрхан сумын Төрийн сан	Дунд	14	Ирүүлээгүй
12	Яруу сумын Төрийн сан	Дунд	11	Ирүүлээгүй
2024 он				
1	Алдархаан сумын Төрийн сан	Их	5	Ирүүлээгүй
2	Дөрвөлжин сумын Төрийн сан	Дунд	5	Ирүүлээгүй
3	Завханмандал сумын Төрийн сан	Дунд	5	Ирүүлээгүй
4	Ургамал сумын Төрийн сан	Их	5	Ирүүлээгүй
5	Эрдэнэхайрхан сумын Төрийн сан	Дунд	5	Ирүүлээгүй
2025 он				
1	Баянхайрхан сумын Төрийн сан	Их	4	Ирүүлээгүй
2	Тосонцэнгэл сумын Төрийн сан	Их	4	Ирүүлээгүй
3	Түдэвтэй сумын Төрийн сан	Дунд	4	Ирүүлээгүй
4	Тэлмэн сумын Төрийн сан	Дунд	4	Ирүүлээгүй
5	Сонгино сумын Төрийн сан	Дунд	4	Ирүүлээгүй

Төлөвлөгөөт хяналт хэрэгжүүлсэн сумдын төрийн сангуудад 2023-2025 онуудад, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр нийт 240 зөвлөмж зөвлөмж хүргүүлсэн байна

Сумдын төрийн сангууд гаргасан зөрчлөө арилган биелэлт ирүүлдэггүй, аймгийн төрийн сангийн дотоод хяналт нь биелэлтийг тооцож ажиллахгүй байгаа нь цаашид энэ зөрчлүүд давтан гарах, эрдэлтэй байна. Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журмын 8.1.19-д “Аймаг, нийслэлийн төрийн сан нь дотоод хяналтын нэгтгэсэн тайлан, зөвлөмжийн хэрэгжилтийг тухайн шатны засаг даргад танилцуулж, энэ зааврын хавсралт 8-д заасан дотоод хяналтын тайлангийн загварын дагуу нэгтгэн, энэ зааврын хавсралт 9-д заасан зөвлөмжийн хэрэгжилтийн тайлан, эрсдэлийн үнэлгээний нэгтгэлийн хамт төв төрийн санд дараа оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн дотор цахимаар болон албан бичгээр хүргүүлнэ” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Аудитын илрүүлэлт

Төрийн сангийн төлөвлөгөөт хяналтаар өгсөн зөвлөмжийг хэрэгжилтийн биелэлтийг тооцож ажиллаагүй байна.

2.3.2. Өдөр тутмын дотоод хяналт сул байгаагаас төлбөр тооцоонд гарч байгаа төрийн сангийн зөрчил давтагдан гарсан байна.

Төрийн сангийн үйл ажиллагаанд гарч болзошгүй эрсдэлийг аргачлалын дагуу үнэлсэн эсэхийг хянаж үзэхэд аймаг сумын төрийн сан нь дотоод хяналтын зааврын дагуу төрийн сангийн эрсдэлийг үнэлэн, хүснэгтийг бөглөн тайлан гаргаж аймгийн төрийн сан болон төв төрийн санд хүргүүлнэ гэж заажээ.

Төрийн сангийн үйл ажиллагаанд гарч болзошгүй эрсдэлийг заавар аргачлалын дагуу 5 маягтаар үнэлсэн эсэхийг хянаж үзэхэд 2023, 2024 онуудад төрийн сангийн эрсдэлийг үнэлэх хуудас /хавсралт 1/, /хавсралт 2/-оор, 2025 онд / хавсралт 1/-ээр хагас дутуу үнэлсэн байгаа нь Сангийн сайдын 2024 оны 254 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн сангийн дотоод хяналтын заавар”-ын 5.1.1 “Сум дүүргийн төрийн сан нь энэ зааврын хавсралт 1,2,4-6,-д заасны дагуу өөрийн төрийн сангийн эрсдэлийн үнэлгээг хийж, энэ зааврын хавсралт 3-т заасны дагуу эрсдэлийн түвшнийг нэгдсэн хүснэгтэд бөглөн, энэ зааврын хавсралт 10-т заасны дагуу эрсдэлийн удирдлагын мөрөөр хэрэгжүүлсэн тайлангийн хамт дараа оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн дотор аймаг, нийслэлийн төрийн санд хүргүүлнэ”, “Аймаг, нийслэлийн төрийн сангийн дотоод хяналт хариуцсан эрх бүхий албан тушаалтан нь энэ зааврын хавсралт 1,2,4-6,-д заасны дагуу өөрийн төрийн сангийн эрсдэлийн үнэлгээг хийж харьяа төрийн сангаас ирүүлсэн эрсдэлийн үнэлгээг нягталж, энэ зааврын/ хавсралт 3/-т заасны дагуу эрсдэлийн түвшнийг нэгдсэн хүснэгтэд бөглөн, энэ зааврын хавсралт 10-т заасны дагуу эрсдэлийн удирдлагын мөрөөр хэрэгжүүлсэн тайлангийн хамт дараа оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн дотор төв төрийн санд хүргүүлнэ” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Аймгийн Төрийн сангийн өдөр тутмын хяналтыг дотоод хяналтын мэргэжилтэн, сумдын хувьд төрийн сангийн албаны дарга нар гүйцэтгэж байгаа боловч өдөр тутмын гүйлгээнд хэрэгжүүлсэн хяналтаар илэрсэн алдаа зөрчил болон залруулсан гүйлгээний талаар тайлан мэдээг аймаг, сумдын төрийн сангууд гаргаагүй, энэ талаар баримт материал байхгүй байна.

Энэ нь Сангийн сайдын 254 дүгээр тушаалаар баталсан Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журмын 4.4-т “Өдөр тутмын дотоод хяналтыг “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.9.7-д заасны дагуу төв төрийн сан болон аймаг, нийслэлийн төрийн сангийн дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн нь харьяа төрийн сангаас түүвэр байдлаар сонгон авч, хяналтын дэлгэцээс эрсдэлтэй гүйлгээнүүдэд анхаарал хандуулж, эрсдэлээс сэргийлж,мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч энэ тухайгаа тухайн жилийн дотоод хяналтын тайланд тусгаж ажиллана” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Иймд аймаг сумдын санхүүгийн албаны дарга болон, хяналт хэрэгжүүлэх эрх бүхий албан тушаалтнууд тухайн төрийн сангийн төлбөр, тооцооны гүйлгээнд өдөр тутмын хяналтыг хэрэгжүүлж байгаа талаараа цахим болон цаасан архив үүсгэж, баримтжуулах шаардлагатай байна.

Аудитын илрүүлэлт

- Төрийн сангийн үйл ажиллагаанд гарч болзошгүй эрсдэлийг журамд заасны дагуу маягт-4,5,6-аар үнэлээгүй байна.
- Төрийн сангийн өдөр тутмын хяналтыг аймаг сумдын хянах эрх бүхий албан тушаалтнууд хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2.3.3 Тайлант онуудад аймаг сумдын төрийн сангуудад хөндлөнгийн хяналт хийгдээгүй байна.

Төрийн аудитын газар нь төрийн сангийн нэгдсэн дансны үлдэгдэл, төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл, санхүүгийн тайланд жил бүр аудит хийж гүйцэтгэдэг.

2023-2025 онуудад Аймгийн Засаг даргын нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар төрийн сантай холбоотой алдаа зөрчил илрээгүй байна.

ДҮГНЭЛТ

1. Аймаг, сумдын Төрийн сангууд сар бүрийн гүйлгээ хаах цаг (14:00) хугацааг мөрдөөгүй, систем дэх цахим эрхийг хугацаанд нь хязгаарлаагүйгээс шалтгаалан зарлагын гүйлгээг холбогдох журмыг зөрчин баталгаажуулсан байна.
2. Төрийн сангаас өндөр үнийн дүнтэй гүйлгээ болон ачаалал ихтэй саруудын гүйлгээг анхан шатны баримтгүйгээр баталгаажуулж байна.
3. Төрийн сангийн үйл ажиллагаатай холбоотой ТЕЗ-ын тушаал, шийдвэрүүд гараагүй байна.
4. Аймаг, сумын төрийн сан нь Засаг даргын Тамгын газартаа харьяалагдаж үйл ажиллагаа явуулж байгаа нь төрийн сангийн бодлого тогтолцоо, үйл ажиллагааг хууль эрх зүйд нийцүүлэн бие даан явуулж чадахгүй байх эрсдэлийг дагуулж байна.
5. Сумдын төрийн сангийн албаны дарга, төсөв төрийн сангийн мэргэжилтний гүйцэтгэж буй зарим чиг үүргүүд хоорондоо давхардаж байна.
6. Системийн үндсэн бүтэц, хэрэглээ нь хэрэглэгчийн хэрэгцээг 98 хувь бүрэн хангаж байгаа боловч, мэдээллийн аюулгүй байдлыг бүрэн шийдэж, "бусад системтэй автомат холболт хийх" шаардлагатай байна.
7. Төсвийн санхүүжилтийг батлагдсан төсвийн хуваариас зөрүүтэй, журамд заасан хугацааг баримтлахгүй, хоцроож олгож байна.
8. Төсвийн хөрөнгө оруулалттай холбоотой дансны зарцуулалтын эрхийг нээхдээ журам зөрчин нээж байгаа нь төсвийн зарцуулалтад тавих хяналтыг сулруулж байна.
9. Аймаг, сумдын төрийн сан дансны үлдэгдлээ төсвийн байгууллагуудтай тулгадаг хэдий ч хагас жил тутмын тооцооны үлдэгдлийн баталгаажуулалт тогтмолжоогүй байна.
10. Аймаг, сумдын Төрийн сан, төсвийн байгууллагууд төсвийн хөрөнгийг анхан шатны баримт, зохих шийдвэр, зөвшөөрөлгүйгээр буюу зориулалтын бусаар зарцуулсан зөрчил гаргажээ.
11. Сумдын бүртгэлийн дансны тодорхойгүй орлогын буцаалтын залруулгыг хийхдээ нийт 118.2 сая төгрөгийн гүйлгээг хууль тогтоомжид заасны дагуу холбогдох баримтыг үндэслэн бүрэн баталгаажуулаагүй байна.
12. Төсвийн гүйцэтгэлийн тайлан, тооцоог холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хугацаанд нь, иж бүрэн боловсруулж тайлагнаагүй байна.
13. Дотоод хяналтаар төрийн сангуудад өгсөн зөвлөмжийн биелэлтийн хэрэгжилтийг тооцоогүй, холбогдох арга хэмжээг авч ажиллаагүй байна.
14. Өдөр тутмын дотоод хяналт сул байгаагаас төлбөр тооцоонд гарч байгаа төрийн сангийн зөрчил давтагдан гарсан байна.

15. Сумдын бүртгэлийн дансанд орсон тодорхойгүй орлогыг буцаалт болон, залруулах гүйлгээг анхан шатны баримтын бүрдэлгүй гүйлгээг баталгаажуулж байна.
16. Сумдын төрийн сангийн албан хаагчдын гүйцэтгэж буй зарим чиг үүргүүд давхардаж байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна.

АЙМГИЙН ТӨРИЙН САНД:

1. Нэмэлт төсвийн санхүүжилт олгохдоо журмын дагуу анхан шатны баримтын бүрдлийг хянан үзэж эрхийг нээж байх;
2. Техник хяналтын болон барьцаа хөрөнгийн дансны зарцуулах эрхийг зориулалт бус зардал болон барьцаа хөрөнгийг чөлөөлөх хугацаа болоогүй байхад нээхгүй байх;
3. Сар бүрийн эцсийн ажлын өдрийн, төсвийн жилийн хаалтын хугацаатай холбоотой чиглэлийг төсвийн байгууллага болон аймаг, сумдын төрийн сангуудад урьдчилан хүргүүлж, хэрэгжилтэд тогтмол хяналт тавих;
4. ХХОАТ-ын буцаан олголтын гүйлгээг хийхдээ зардлын эдийн засгийн ангиллын дагуу шилжүүлж байх;
5. Төрийн сангийн төлөвлөгөөт хяналтаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн биелэлтийг тооцож ажиллах;
6. Төрийн сангийн үйл ажиллагаанд гарч болзошгүй эрсдэлийг журамд заасан маягт-4,5,6-аар үнэлж хэвших;

АЙМАГ, СУМДЫН ТӨРИЙН САНД:

1. Төрийн сангийн удирдлагын цахим системд, зарлага, төрийн сангийн бүртгэлийн дансны тодорхойгүй орлого, залруулга, буцаалтын гүйлгээний анхан шатны баримтын бүрдүүлэлтэд хяналтыг сайжруулах;
2. Төрийн сангийн өдөр тутмын хяналтыг аймаг, сумдын хянах эрх бүхий албан тушаалтнууд хэрэгжүүлэх;

ҮАГ-Т ХҮРГҮҮЛЭХ САНАЛ:

Сумын төрийн сангийн албаны дарга болон төсөв төрийн сангийн мэргэжилтний ажлын чиг үүргийг тодорхой болгож, албан тушаалын тодорхойлолтыг журамд заасны дагуу шинэчлэн батлуулах.

Дээрх зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 25-ны дотор Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

БАЙГУУЛЛАГААС ИРСЭН САНАЛ ТАЙЛБАР:



**ЗАВХАН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Хатанбаатар Магсаржавын 1-116 тоот
Улиастай сум, Завхан аймаг 81090
Утас: 7575-1155, Факс: 7046-2550
Цахим шуудан: info@zavkhan.gov.mn
Цахим хуудас: Zavkhan.gov.mn

2026.05.29 № 08/583
танай _____ -ны № _____ т

**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Танай байгууллагаас ирүүлсэн "Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомийн нийцэл" сэдэвт нийцлийн аудитын хүрээнд дараах саналыг хүргүүлж байна.

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙН ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.ЧАДРААБАЛ



8126170032
D:\2022\BICHIG НЭРЭГ\AS

Завхан аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсийн санал тайлбар

№	Аудитын чиглэл/ асуулт	Алдаа зөрчлийн товч утга	Шалгагдагч байгууллагын санал, тайлбар
1	2.1.2. Төсвийн зарцуулалтын эрх олголт нь батлагдсан төсөв, зориулалт, эдийн засгийн ангилал болон шаардлагад нийцэж хэрэгжиж байна уу?	Барьцаа хөрөнгийн дансны орон нутгийн төсвөөр хэрэгжих хөрөнгө оруулалтын ажлыг санхүүжүүлсэн, урсгал зардлын гүйлгээний эрх нээсэн, барьцааг чөлөөлөх хугацаа болоогүй байхад эрх нээж барьцаа хөрөнгийг чөлөөлсөн 685.5 сая төгрөгийн 14 гүйлгээний эрхийг нээсэн байна. Мөн захиалагчийн хяналтын зориулалт бус 86 гүйлгээний 982.2 сая төгрөгийн зарцуулах эрхийг нээсэн байна	Хасуулах саналтай байна. Энэ зөвлөмж нь Санхүүгийн тайлагналын аудитын зөвлөмжтэй давхцаж байна.
2	2.2.2. Төрийн сан, төсвийн байгууллага бүртгэлийн дансны төлбөр тооцоо, төлбөрийн хүсэлт, зарлагын гүйлгээг хийхдээ эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга тэмдэг, үндэслэх баримт бичиг, мэдээллийг үнэн зөв бүрдүүлж, зориулалт, ангиллын дагуу гүйцэтгэсэн үү?	Аймаг, сумдын төрийн сан төсвийн жилийн хаалттай холбоотойгоор төсвийн байгууллагуудын зарлагын гүйлгээг хянах, баталгаажуулах эрхийг тогтоосон хугацаанд хаах чиглэлийг бүрэн хэрэгжүүлээгүй байдлын улмаас эрх хаагдсан хугацаанаас хойш 2024 онд 122.0 сая төгрөгийн 64 гүйлгээ, 2025 онд 1,966.3 сая төгрөгийн 461 гүйлгээг тус тус шилжүүлсэн байна. мөн Аймаг, сумын төрийн сан нь сар бүрийн эцсийн ажлын өдрийн 14:00 цагт зарлагын гүйлгээг хаах журам, чиглэлийг бүрэн хэрэгжүүлээгүй байдлын улмаас хаалтын хугацаанаас хойш 2024 онд 1,207.1 сая төгрөгийн 572 гүйлгээ, 2025 онд 2,067.7 сая төгрөгийн 899 гүйлгээг тус тус шилжүүлсэн байна.	Хасуулах саналтай байна. Хаалт сунгах хугацааг Сангийн яам шийдвэрлэдэг.Аймгийн төрийн сангаас хамаардаггүй болно.
3	2.2.3. Төв төрийн сан, бүртгэлийн дансны тодорхойгүй орлого, буцаалтыг журмын дагуу дансанд байршуулж, холбогдох баримтыг үндэслэн гүйлгээг залруулан буцааж байна уу?	Тайлант хугацаанд сумдын бүртгэлийн дансны тодорхойгүй орлогын буцаалтын залруулгыг хийхдээ нийт 118.2 сая төгрөгийн гүйлгээний анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлээгүй байна.	Тодорхойгүй орлого гэдгийг тодруулая. Хасуулах саналтай байна.Улсын тэмдэгтийн хураамж болон андуурч орж ирсэн гүйлгээг иргэн аж ахуй нэгжийн өргөдөл хүсэлтийг үндэслэн гаргаж баримтын харилцах дансны мемралд үлдэж болно.
4		Төрийн сангийн удирдлагын цахим системд шилжсэнээр аймаг, сумдын Төрийн сан бүртгэлийн дансны төлбөрийн залруулгыг хийхдээ мемориалын баримт үйлдэхгүйгээр гүйцэтгэсэн байна.	Хасуулах саналтай байна. Онлайнаар хийгддэг учир цаасан баримт үйлдэгддэггүй болно.

ИРҮҮЛСЭН САНАЛД ӨГСӨН ХАРИУ ТАЙЛБАР:

№	Ирүүлсэн санал, тайлбар	Төрийн аудитын газрын шийдвэр
Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсээс ирүүлсэн санал:		
1	Барьцаа хөрөнгийн дансны орон нутгийн төсвөөр хэрэгжих хөрөнгө оруулалтын ажлыг санхүүжүүлсэн, урсгал зардлын гүйлгээний эрх нээсэн, барьцааг чөлөөлөх хугацаа болоогүй байхад эрх нээж барьцаа хөрөнгийг чөлөөлсөн 685.5 сая төгрөгийн 14 гүйлгээний эрхийг нээсэн байна. Мөн захиалагчийн хяналтын зориулалт бус 86 гүйлгээний 982.2 сая төгрөгийн зарцуулах эрхийг нээсэн байна. асуулах саналтай байна. Энэ зөвлөмж нь Санхүүгийн тайлагналын аудитын зөвлөмжтэй давхцаж байна. Тиймээс үүнийг хасуулах саналтай байна.	ТЕЗ-ийн Санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар өгсөн зөвлөмжүүд нь төсвийг зориулалт бусаар зарцуулсан зарцуулалтад өгсөн зөвлөмж. Харин энэ илэрсэн алдаа нь төрийн сангийн зарцуулах эрхийг журмаа зөрчин барьцаа хөрөнгийн болон техник хяналтын зардлын дансны эрх нээж байгаа нь төрийн сангийн буруутай үйлдэл болно.
2	“Аймаг, сумдын төрийн сан төсвийн жилийн хаалттай холбоотойгоор төсвийн байгууллагуудын зарлагын гүйлгээг хянах, баталгаажуулах эрхийг тогтоосон хугацаанд хаах чиглэлийг бүрэн хэрэгжүүлээгүй байдлын улмаас эрх хаагдсан хугацаанаас хойш 2024 онд 122.0 сая төгрөгийн 64 гүйлгээ, 2025 онд 1,966.3 сая төгрөгийн 461 гүйлгээг тус тус шилжүүлсэн байна. мөн Аймаг, сумын төрийн сан нь сар бүрийн эцсийн ажлын өдрийн 14:00 цагт зарлагын гүйлгээг хаах журам, чиглэлийг бүрэн хэрэгжүүлээгүй байдлын улмаас хаалтын хугацаанаас хойш 2024 онд 1,207.1 сая төгрөгийн 572 гүйлгээ, 2025 онд 2,067.7 сая төгрөгийн 899 гүйлгээг тус тус шилжүүлсэн байна.” гэсэн хэсгийг хасуулах саналтай байна. Хаалт сунгах хугацааг Сангийн яам шийдвэрлэдэг. Аймгийн төрийн сангаас хамаардаггүй болно.	Төрийн сангийн дансны жилийн эцсийн хаалт сунгахыг Сангийн яам шийдвэрлэж байгаа бол Аймаг, сумдын төрийн сан төсвийн жилийн хаалттай холбоотойгоор төсвийн байгууллагуудын зарлагын гүйлгээг хянах, баталгаажуулах эрхийг тогтоосон хугацаанд хаах чиглэлийг бүрэн хэрэгжүүлээгүй байдлын улмаас эрх хаагдсан хугацаанаас хойш 2024 онд 122.0 сая төгрөгийн 64 гүйлгээ, 2025 онд 1,966.3 сая төгрөгийн 461 гүйлгээг тус тус шилжүүлсэн байна гэсэн хэсгийг хасаж шийдвэрлэлээ.
3	“Тайлант хугацаанд сумдын бүртгэлийн дансны тодорхойгүй орлогын буцаалтын залруулгыг хийхдээ нийт 118.2 сая төгрөгийн гүйлгээний анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлээгүй байна.” гэсэн хэсгээс тодорхойгүй орлого гэдгийг тодруулъя. Хасуулах саналтай байна. Улсын тэмдэгтийн хураамж болон андуурч орж ирсэн гүйлгээг иргэн аж ахуй нэгжийн өргөдөл хүсэлтийг үндэслэн гаргаж баримтын харилцах дансны мемориалд үддэг болно.	Тодорхойгүй орлого гэдэг нь данс андуурч гүйлгээ хийсэн орлогыг нэр данс зөрүүтэй ангиллаар буцаан шилжүүлэхдээ холбогдох анхан шатны бүрдүүлэлтийг хангалттай хийгээгүй зөрчил илэрсэн тул хасах боломжгүй байна.

ТӨРИЙН САНГИЙН ТОГТОЛЦОО, ХУУЛЬ ТОГТООМЖИЙН НИЙЦЭЛ

4	Төрийн сангийн удирдлагын цахим системд шилжсэнээр аймаг, сумдын Төрийн сан бүртгэлийн дансны төлбөрийн залруулгыг хийхдээ мемориалын баримт үйлдэхгүйгээр гүйцэтгэсэн байна. гэсэн хэсгийг Хасуулах саналтай байна. Онлайнаар хийгддэг учир цаасан баримт үйлдэгддэггүй болно.	Төрийн сангийн удирдлагын цахим системд шилжсэнээр аймаг, сумдын Төрийн сан бүртгэлийн дансны төлбөрийн залруулгыг хийхдээ мемориалын баримт үйлдэхгүйгээр гүйцэтгэсэн байна. гэсэн хэсгийг тайлангийн хэсэг болон зөрчлөөс хаслаа.
----------	--	--